



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/164/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261885 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Энхжаргал
Утас: 261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт	21
4.1 Албан шаардлага	21
4.2 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНС	Засгийн газрын нөөц сан
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022-02-25 № 84/418
танай _____-ны № _____-т

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ
ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН:
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,052,899,809.77	11,952,748,941.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,122,948,494.04	0.00
31200	Банканд байгаа бэлэн мөнгөн	1,122,948,494.04	0.00
31210	Төгрөг	1,122,948,494.04	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	1,122,948,494.04	0.00
33	АВЛАГА	1,976,189,446.11	403,116,621.16
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,946,629,446.11	397,116,621.16
33500	Бусад авлага	29,560,000.00	6,000,000.00
33510	Байгууллагаас авах авлага	29,560,000.00	6,000,000.00
34	УРЬДЧИЛГАА	1,063,656,008.50	8,707,307,266.24
34600	Урьдчилж гарсан зардал	1,063,656,008.50	8,707,307,266.24
35	БАРАА МАТЕРИАЛ	2,890,105,861.12	2,842,325,054.20
35100	Түүхий эд материал	1,379,111,346.57	1,322,379,202.77
35110	Тусгай зориулалттай материал	1,378,952,346.57	1,275,946,102.77
35130	Эм боох материал	159,000.00	46,433,100.00
35400	Хангамжийн материал	1,510,994,514.55	1,519,945,851.43
35410	Бичиг хэргийн материал	49,304,230.00	120,876,230.00
35420	Аж ахуйн материал	112,812,359.60	392,800,975.68
35430	Сэлбэг хэрэгсэл	40,290,000.00	79,923,138.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	56,975,730.05
35450	Барилгын засварын материал	0.00	3,421,600.00
35470	Бусад хангамжийн материал	1,308,587,924.95	865,948,177.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,718,648,346.25	4,803,869,175.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,718,648,346.25	4,803,869,175.08
39200	Биет хөрөнгө	4,389,017,747.94	4,378,761,921.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,542,964,144.19	3,542,964,144.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(295,692,991.64)	(425,635,382.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	92,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(4,600,000.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,072,897,489.15	11,139,551,708.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,214,819,343.50)	(10,206,097,581.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	704,231,036.25	636,857,556.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	(421,547,497.26)	(397,248,618.45)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,880,091.55	12,880,091.55
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,895,180.80)	(11,909,996.96)
39300	Биет бус хөрөнгө	329,630,598.31	425,107,253.26
39301	Программ хангамж	23,897,512.80	118,951,820.80
39302	Хуримтлагдсан элэгдэл	(14,465,834.49)	(14,043,487.54)
39303	Бусад биет бус хөрөнгө	320,198,920.00	320,198,920.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,771,548,156.02	16,756,618,116.68
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,331,268,546.36	158,562,312.87
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,331,268,546.36	158,562,312.87
41200	Богино хугацаат зээлийн өглөг	183,814,452.32	158,502,312.87
41210	Төгрөг	183,814,452.32	158,502,312.87
41217	Санхүүгийн бусад байгууллага	183,814,452.32	158,502,312.87
41300	Өглөг	1,147,454,094.04	60,000.00
41360	Бусад өглөг	1,147,454,094.04	60,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,126,054,094.04	60,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	21,400,000.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,440,279,609.66	16,598,055,803.81
51	Засгийн газрын хувь оролцоо	10,440,279,609.66	16,598,055,803.81

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51100	Засгийн газрын оруулсан капитал	470,087,565.96	470,087,565.96
51200	Хуримтлагдсан үр дүн	7,485,541,781.03	13,643,317,975.18
51210	Өмнөх үеийн үр дүн	7,562,061,363.61	7,485,550,561.03
51220	Тайлант үеийн үр дүн	(76,519,582.58)	6,157,767,414.15
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,484,650,262.67	2,484,650,262.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,771,548,156.02	16,756,618,116.68

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	44,244,931,775.11	58,380,431,068.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,405,000.00	484,315,613.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,405,000.00	484,315,613.00
120009	Бусад орлого	0.00	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,405,000.00	484,315,613.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	44,238,526,775.11	57,896,115,455.26
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	27,029,650,700.00	40,872,001,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	27,029,650,700.00	40,872,001,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,208,876,075.11	17,024,113,955.26
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,342,145,601.30	187,176,769.00
131103	ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,967,140,877.81	14,272,323,559.60
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	356,500,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,543,089,596.00	2,564,613,626.66
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	44,111,451,357.69	52,195,722,075.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	44,111,451,357.69	52,176,218,875.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,303,770,035.25	43,783,716,910.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,184,110,104.10	2,543,800,758.34
210101	Үндсэн цалин	1,127,700,400.00	1,307,691,700.00
210102	Нэмэгдэл	947,247,604.10	1,109,043,658.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	109,162,100.00	127,065,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,619,200.00	51,676,776.84
210201	Тэтгэврийн даатгал	1,581,499.33	663,163.00
210202	Тэтгэмжийн даатгал	116,988.00	69,809.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	93,590.00	55,846.00
210204	Ажилгүйдлийн даатгал	23,398.00	13,963.00
210205	Эрүүл мэндийн даатгал	44,803,724.67	50,873,995.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	158,436,358.56	155,386,276.41
210301	Гэрэл, цахилгаан	98,285,208.44	98,409,886.68
210302	Түлш, халаалт	30,194,495.74	27,428,447.69
210303	Цэвэр, бохир ус	5,541,901.58	8,377,609.00
210304	Байрны түрээс	24,414,752.80	21,170,333.04
2104	Хангамж, бараа материалын зардал	351,286,195.41	1,364,825,763.59
210401	Бичиг хэрэг	181,983,134.40	117,584,783.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	1,105,260,936.65
210404	Ном, хэвлэл	42,605,776.71	29,627,285.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,770,000.00	3,014,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	124,927,284.30	109,337,958.92
2105	Нормативт зардал	3,724,506,438.13	5,274,022,438.25
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,885,057.00	22,946,890.00
210502	Хоол, хүнс	7,113,998.00	5,212,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,694,507,383.13	5,245,863,548.25
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,688,051,940.67	3,403,417,504.16

АХГ-2022/164/НА-СТА-ТШЗ

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	1,426,215,900.10	2,661,377,703.16
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	90,170,470.53	11,526,004.00
210604	Урсгал засвар	1,171,665,570.04	730,513,797.00
2107	Томилолт, зочны зардал	11,862,080.00	1,344,500.00
210702	Дотоод албан томилолт	11,862,080.00	1,344,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,627,494,490.03	12,045,620,756.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,184,754,549.19	9,494,951,635.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	442,380,416.72	2,538,625,895.10
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	3,723,100.00
210807	Газрын төлбөр	359,524.12	6,820,125.65
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,511,403,228.35	18,943,622,136.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,356,729,041.00	18,278,326,210.17
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	94,195,043.70	157,166,672.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,060,479,143.65	508,129,254.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,807,681,322.44	8,392,501,964.99
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	169,509,240.00	105,735,813.75
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	169,509,240.00	105,735,813.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,630,452,248.00	8,248,663,770.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	200,000,000.00	136,740,950.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,475,000.00	4,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,151,225,500.00	7,839,779,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	274,751,748.00	267,643,720.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,719,834.44	38,102,381.24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,719,834.44	23,861,260.34
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг – нэмэлт	0.00	14,241,120.90
22	Хөрөнгийн зардал	0.00	19,503,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	19,503,200.00
223001	Бусад хөрөнгө	0.00	19,503,200.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	133,480,417.42	6,184,708,993.10
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	210,000,000.00	26,941,578.95
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	210,000,000.00	26,941,578.95
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(210,000,000.00)	(26,941,578.95)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(76,519,582.58)	6,157,767,414.15

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,087,565.96	2,484,650,262.67	7,562,061,363.61	10,516,799,192.24
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	470,087,565.96	2,484,650,262.67	7,562,061,363.61	10,516,799,192.24
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(76,519,582.58)	(76,519,582.58)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,087,565.96	2,484,650,262.67	7,485,541,781.03	10,440,279,609.66
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,087,565.96	2,484,650,262.67	7,485,541,781.03	10,440,279,609.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	8,780.00	8,780.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	470,087,565.96	2,484,650,262.67	7,485,550,561.03	10,440,288,389.66
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	6,157,767,414.15	6,157,767,414.15
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,087,565.96	2,484,650,262.67	13,643,317,975.18	16,598,055,803.81

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	70,339,444,889.42	65,961,740,885.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,100,918,114.31	6,118,995,984.58
120	Нийтлэг татварын бус орлого	26,100,918,114.31	6,118,995,984.58
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	26,100,918,114.31	6,118,995,984.58
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	6,118,995,984.58
120009	Бусад орлого	26,100,918,114.31	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	44,238,526,775.11	59,842,744,901.37
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	27,029,650,700.00	40,872,001,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	27,029,650,700.00	40,872,001,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,208,876,075.11	18,970,743,401.37
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,342,145,601.30	187,176,769.00
131103	ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,967,140,877.81	15,444,135,992.41
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	356,500,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,543,089,596.00	3,339,430,639.96
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	68,727,312,375.38	60,030,847,468.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	68,727,312,375.38	60,030,847,468.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,338,723,606.83	51,234,318,852.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,184,110,104.10	2,543,800,758.34
210101	Үндсэн цалин	1,127,700,400.00	1,307,691,700.00
210102	Нэмэгдэл	947,247,604.10	1,109,043,658.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	109,162,100.00	127,065,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,619,200.00	51,676,776.84
210201	Тэтгэврийн даатгал	1,815,475.33	3,879,534.00
210205	Эрүүл мэндийн даатгал	44,803,724.67	47,797,242.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	236,058,705.74	180,698,415.86
210301	Гэрэл, цахилгаан	98,285,208.44	98,409,886.68
210302	Түлш, халаалт	30,194,495.74	27,428,447.69
210303	Цэвэр, бохир ус	5,541,901.58	8,377,609.00
210304	Байрны түрээс	102,037,099.98	46,482,472.49
2104	Хангамж, бараа материалын зардал	174,809,966.71	1,774,062,638.02
210401	Бичиг хэрэг	23,756,240.00	53,461,080.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	1,491,373,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,605,776.71	29,627,285.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,770,000.00	3,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	106,677,950.00	196,100,573.00
2105	Нормативт зардал	4,162,053,664.00	5,960,440,055.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,251,670,120.00	5,573,990.00
210502	Хоол, хүнс	7,701,044.00	9,384,135.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,902,682,500.00	5,945,481,930.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,017,984,053.00	1,276,098,796.00

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	506,599,356.00	593,913,399.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	223,329,220.00	54,430,300.00
210604	Урсгал засвар	1,288,055,477.00	627,755,097.00
2107	Томилолт, зочны зардал	11,862,080.00	1,344,500.00
210702	Дотоод албан томилолт	11,862,080.00	1,344,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,847,616,743.31	13,445,619,734.79
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,186,223,415.19	9,916,578,894.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	661,033,804.00	3,516,997,614.70
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	3,723,100.00
210807	Газрын төлбөр	359,524.12	6,820,125.65
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,657,609,089.97	26,000,577,177.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,545,730,046.27	25,813,700,477.49
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	111,879,043.70	186,876,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,388,588,768.55	8,796,528,616.15
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	169,509,240.00	105,735,813.75
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	169,509,240.00	105,735,813.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,621,230,248.00	8,255,573,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	200,000,000.00	136,740,950.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,475,000.00	4,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,141,225,500.00	7,839,779,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	275,529,748.00	274,553,750.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,597,849,280.55	435,219,002.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,719,834.44	23,861,260.34
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг - нэмэлт	1,590,129,446.11	411,357,742.06
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,612,132,514.04	5,930,893,417.46
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	489,184,020.00	7,053,841,911.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	489,184,020.00	7,053,841,911.50
2200	Дотоод эх үүсвэрээр	489,184,020.00	7,053,841,911.50
223001	Бусад хөрөнгө	0.00	6,496,766,716.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	489,184,020.00	557,075,195.50
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(489,184,020.00)	(7,053,841,911.50)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,122,948,494.04	-1,122,948,494.04
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,122,948,494.04
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,122,948,494.04	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,122,957,274.04		
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,872,001,500.00	40,848,140,239.66	23,861,260.34	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,372,001,500.00	34,351,373,523.66	20,627,976.34	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,009,988,700.00	25,990,063,909.91	19,924,790.09	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,544,567,000.00	2,543,800,758.34	766,241.66	100.0
210101	Үндсэн цалин	1,307,691,700.00	1,307,691,700.00	0.00	100.0
210102	Нэмэгдэл	1,109,809,900.00	1,109,043,658.34	766,241.66	99.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	127,065,400.00	127,065,400.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,911,200.00	51,676,776.84	2,234,423.16	95.9
210201	Тэтгэврийн даатгал	51,139,000.00	3,879,534.00	47,259,466.00	7.6
210202	Тэтгэмжийн даатгал	418,000.00	0.00	418,000.00	0.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,354,200.00	47,797,242.84	(45,443,042.84)	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	194,343,500.00	180,698,415.86	13,645,084.14	93.0
210301	Гэрэл, цахилгаан	96,980,700.00	98,409,886.68	(1,429,186.68)	101.5
210302	Түлш, халаалт	39,733,700.00	27,428,447.69	12,305,252.31	69.0
210303	Цэвэр, бохир ус	10,698,400.00	8,377,609.00	2,320,791.00	78.3
210304	Байрны түрээс	46,930,700.00	46,482,472.49	448,227.51	99.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,774,507,300.00	1,774,062,638.02	444,661.98	100.0
210401	Бичиг хэрэг	53,461,800.00	53,461,080.00	720.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,491,373,700.00	1,491,373,700.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,081,100.00	29,627,285.02	453,814.98	98.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	196,090,700.00	196,100,573.00	-9,873.00	100.0
2105	Нормативт зардал	5,960,445,800.00	5,960,440,055.00	5,745.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,574,000.00	5,573,990.00	10.00	100.0
210502	Хоол, хүнс	9,389,100.00	9,384,135.00	4,965.00	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,945,482,700.00	5,945,481,930.00	770.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,599,686,300.00	1,599,663,411.00	22,889.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	912,220,100.00	912,198,014.00	22,086.00	100.0
210602	Тавилга	5,280,000.00	5,280,000.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	54,430,300.00	54,430,300.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	627,755,900.00	627,755,097.00	803.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,344,500.00	1,344,500.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	1,344,500.00	1,344,500.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,505,370,400.00	13,502,576,935.29	2,793,464.71	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,974,777,200.00	9,973,536,094.94	1,241,105.06	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	3,517,805,900.00	3,516,997,614.70	808,285.30	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,723,100.00	3,723,100.00	0.00	100.0

**Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210807	Газрын төлбөр	7,397,500.00	6,820,125.65	577,374.35	92.2
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	166,700.00	0.00	166,700.00	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	375,812,700.00	375,800,419.56	12,280.44	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	188,936,000.00	188,923,719.56	12,280.44	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	186,876,700.00	186,876,700.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,362,012,800.00	8,361,309,613.75	703,186.25	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	106,010,000.00	105,735,813.75	274,186.25	99.7
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	106,010,000.00	105,735,813.75	274,186.25	99.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,256,002,800.00	8,255,573,800.00	429,000.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	136,800,000.00	136,740,950.00	59,050.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,839,779,100.00	7,839,779,100.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	274,923,700.00	274,553,750.00	369,950.00	99.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,500,000,000.00	6,496,766,716.00	3,233,284.00	100.0
223001	Бусад хөрөнгө	6,500,000,000.00	6,496,766,716.00	3,233,284.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40,872,001,500.00	40,848,140,239.66	23,861,260.34	99.9
35	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,872,001,500.00	40,848,140,239.66	23,861,260.34	99.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	40,872,001,500.00	40,848,140,239.66	23,861,260.34	99.9
	Тохируулгын өөрчлөлт		1,122,957,274.04		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		18,970,743,401.37
УРСГАЛ ЗАРДАЛ		18,970,743,401.37
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		18,559,385,659.31
Бараа үйлчилгээний бусад зардал		18,559,385,659.31
Бараа үйлчилгээний бусад зардал		18,559,385,659.31
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		411,357,742.06
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		411,357,742.06
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		411,357,742.06
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		18,970,743,401.37
Нэмэлт санхүүжилтийн орлого		18,970,743,401.37
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		187,176,769.00
ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		15,444,135,992.41
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,339,430,639.96

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад авлага, бараа материалын нөөц үүсгэхгүй байх, хөрөнгийн тооллогыг санхүүгийн тайланд тусгаж, ангиллын дагуу зөв бүртгэх, авто тээврийн хэрэгслийн шилжилт, хөдөлгөөнийг хийх, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах, төсвийг үнэн зөв бодитой төлөвлөж, бүртгэх, тайлагнах, зарцуулах, анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 28-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Ц.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Сэржмядаг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 9/144 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Онцгой байдлын ерөнхий газар нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэг бүхий Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, бодлого зохицуулалтыг сайжруулах, үндэсний болон бүс нутаг, олон улсын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх,
2. Гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж бэхжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, инновацийг нэвтрүүлэх,
3. Байгууллагын удирдлагын манлайлал, хүний нөөцийн хөгжлийг хангаж, чадавхыг бэхжүүлэх,
4. Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх нийтийн үйл хэрэг болгон, иргэд, олон нийтийн гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоог хангах,
5. Гамшгаас хамгаалах мэргэжлийн удирдлага зохицуулалтыг сайжруулж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бэхжүүлэх,
6. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, улсын хяналтыг хэрэгжүүлэх замаар галын аюулгүй байдлыг хангах, гал түймэртэй тэмцэх тогтолцоог бэхжүүлж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулах,

7. Улсын нөөцийг удирдлага, зохицуулалтаар хангах, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалтыг сайжруулж, гамшгийн дараах үйл ажиллагааг эрчимжүүлэх,
8. Төсөв санхүү, хангалт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх,
9. Гамшгаас хамгаалах хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг зохион байгуулж гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” болно.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/293 дугаар тушаалаар баталсан НБББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газраас нийслэлийн 5 дүүрэгт иж бүрэн шалгалт хийх, аймаг, нийслэлийн 7 онцгой байдлын газар биелэлтийн шалгалтыг хийх төлөвлөгөө батлагдсан ба Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хяналт-шинжилгээ хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Онцгой байдлын ерөнхий газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 44,111,451.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 441,114.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,985,070.0 мянган төгрөгөөр буюу 42.3 хувиар өсөж, материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, өр төлбөр дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,122,948.5	0.0	(1,122,948.5)
Авлага	1,976,189.4	403,116.6	(1,573,072.8)
Урьдчилгаа	1,063,656.0	8,707,307.3	7,643,651.3
Бараа материал	2,890,105.9	2,842,325.1	(47,780.8)
Үндсэн хөрөнгө	4,718,648.3	4,803,869.2	85,220.8
Нийт хөрөнгийн дүн	11,771,548.2	16,756,618.1	4,985,070.0
Нийт өр төлбөр	1,331,268.5	158,562.3	(1,172,706.2)
Богино хугацаат өр төлбөр	1,331,268.5	158,562.3	(1,172,706.2)
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	10,440,279.6	16,598,055.8	6,157,776.2
Засгийн газрын оролцоо	10,440,279.6	16,598,055.8	6,157,776.2
Засгийн газрын оруулсан капитал	470,087.6	470,087.6	0.0
Хуримтлагдсан үр дүн	7,485,541.8	13,643,318.0	6,157,776.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,484,650.3	2,484,650.3	0.0
Нийт өр төлбөр ба цэвэр өмчийн дүн	11,771,548.2	16,756,618.1	4,985,070.0

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байгаа нь арилжааны банкин дахь тусгаарлах байрны төлбөр 1,122,829.5 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, үлдэгдэл 119,000.1 мянган төгрөгийг төрийн сангийн дансанд шилжүүлж, татаас санхүүжилтийн авлага үүсгэсэн;
- Авлагын дансны үлдэгдэл 403,116.6 мянган төгрөг болж, 1,573,072.8 мянган төгрөгөөр буюу 79.6 хувиар буурсан нь иргэд байгууллагаас өгсөн хандивын үлдэгдэл, ЗГНС-ийн татаас санхүүжилтийн авлага 1,946,629.4 мянган төгрөгийг буцаан авч зарцуулсан;
- Урьдчилж төлсөн зардлын дансны үлдэгдэл 8,707,307.3 мянган төгрөг болж, 7,643,651.3 мянган төгрөгөөр буюу 8.2 дахин өссөн нь хил дээр байгаа бараа материалын тээвэрлэлт саатсантай холбоотой 7,408,012.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бараа материал нийлүүлэгдээгүй, нисдэг тэрэг, алба хаагчдын гэнэтийн ослын даатгал болон нөөцийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, бараа материалын даатгалын хураамж 1,299,294.7 мянган төгрөгийг гэрээний хугацаанд ногдохыг урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн;
- Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 158,562.3 мянган төгрөг болж, 1,172,706.2 мянган төгрөгөөр буюу 8.4 дахин буурсан нь арилжааны банкин дахь хувь хүмүүст өгөх өглөг 1,122,948.5 мянган төгрөгийг барагдуулсан нь тус тус голлон нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Онцгой байдлын ерөнхий газар нь 2021 оны төсвийн төсөлд урсгал зардлыг 54,236,646.7 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг 19,275,400.0 мянган төгрөг нийт 73,512,046.7 мянган төгрөгийг төлөвлөж, санхүүжилтийн эх үүсвэр 73,512,046.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусган дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс нийт зардлыг 32,050,800.0 мянган төгрөгөөр бууруулж, 41,461,246.7 мянган төгрөгөөр баталжээ.

Тухайлбал, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 7,081,800.6 мянган төгрөг, урсгал шилжүүлгийг 19,015,454.7 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг 12,775,400.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, хангамж, бараа материалын зардлыг 1,405,838.5 мянган төгрөг, нормативт зардлыг 1,528,441.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 74,630.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 1,183,832.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Тайлант онд Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орж, урсгал санхүүжилтийг 589,245.2 мянган төгрөгөөр бууруулан 40,872,001.5 мянган төгрөгөөр өөрчлөн баталсан байна. Үүнээс цалингийн зардлыг 625,605.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 404,313.3 мянган төгрөгөөр бууруулан, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 395,326.6 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 243,627.6 мянган төгрөг, нормативт зардлыг 136,963.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээнд зориулан 34,351,373.5 мянган төгрөгийн урсгал зардал, 6,496,766.7 мянган төгрөгийн хөрөнгийн зардал, нийт 40,872,001.5 мянган төгрөгийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 40,872,001.5 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 34,351,373.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 6,496,766.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулж, үлдэгдэл 23,861.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 40,848,140.2 мянган төгрөг буюу 99.9 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь 10, 11 дүгээр сард зарим өрөөний радиатор шугам солих засвар хийснээс шалтгаалан ус хязгаарлан, халаалтаа хугацаанаас нь хоцорч авснаас байр ашиглалттай холбоотой зардал 13,645.1 мянган төгрөг, бусад урсгал зардал 6,982.9 мянган төгрөг, хөрөнгийн зардал 3,233.3 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Код	Нэр				
1	70708	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх	40,872,001.5	40,848,140.2	23,861.3	99.9
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	16,093,816.7	16,075,065.4	18,751.3	99.9

АХГ-2022/164/НА-СТА-ТШЗ

1.2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	27,305.2	27,304.9	0.3	100.0
1.3	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	1,930.6	1,689.6	241.0	87.5
1.4	80215	Эрэм, шинжилгээ судалгааны ажил	10,000.0	9,770.0	230.0	97.7
1.5	80220	Холбооны суваг ашигласны хөлс	449,176.1	449,176.1	0.0	100.0
1.6	80509	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	106,010.0	105,735.8	274.2	99.7
1.7	80703	Өндөр, настан, ахмад дайчдад олгох хөнгөлөлт	4,500.0	4,500.0	0.0	100.0
1.8	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	8,122,702.8	8,122,332.9	370.0	100.0
1.9	80813	Хуульд заасан үндэслэлээр албан хаагчид олгох нөхөн олговор	128,800.0	128,741.0	59.1	100.0
1.10	80918	Бусад	6,500,000.0	6,496,766.7	3,233.3	100.0
1.11	81560	Монголын улаан загалмай нийгэмлэгээр гэрээгээр гүйцэтгүүлэх	107,785.4	107,785.4	0.0	100.0
1.12	82310	Гамшгаас сэргийлэх сургалт сурталчилгаа	268,774.7	268,762.4	12.3	100.0
1.13	82705	Байгалийн гамшиг, ослын үр дагаврыг арилгах	9,051,200.0	9,050,510.2	689.8	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засгийн газрын нөөц сангаас 15,444,136.0 мянган төгрөг, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хүн амын шилжилт хөдөлгөөний байгууллага, Хүн амын сан зэрэг байгууллага болон давсан орлогоос нэмэлтээр бий болсон 3,339,430.6 мянган төгрөг, иргэд байгууллагаас авсан хандив, тусламж 187,176.8 мянган төгрөг, нийт 18,970,743.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа ажил үйлчилгээний зардалд 18,559,385.7 мянган төгрөгийг зарцуулж, 411,357.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан “ТЕЗ нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-ээр Онцгой байдлын ерөнхий газрын хэрэгжүүлэх гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны 1 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээ баталсан байна. Үүнд:

- Байгалийн болон хүний хүчний зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийх;
- Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах хяналт шалгалт;

АХГ-2022/164/НА-СТА-ТШЗ

- Гамшгийн хор уршгийг арилгах, аврах ажлын зориулалттай тусгай багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах;
- Цацраг идэвхт, химийн хорт бодисын болон тэсэрч дэлбэрэх бодисын аюулаас хамгаалах хүн, мал, амьтны гоц халдварт, халдварт өвчин, ой хээр, объектын гал түймэртэй тэмцэх арга хэмжээнүүд болно.

Дээрх хөтөлбөр, арга хэмжээнд Онцгой байдлын ерөнхий газрын аппаратын хэрэгжүүлэх арга хэмжээг батлаагүй бөгөөд хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нэгтгэн авч үзэх нь зүйтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу авсан судалгаанд анхаарал татсан асуудал гараагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/293 дугаар тушаалаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг баталсан байна. НБББББ-т байгууллагын нийтлэг зориулалттай санхүүгийн тайланд тавигдах шаардлагыг тусгасан боловч холбогдох хууль, тогтоомж, Сангийн сайдын баталсан тушаал шийдвэрийн өөрчлөлтүүд болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын шинэчлэлийг тусган сайжруулах шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 8 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Гамшгаас хамгаалах тухай хуульд 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдөр орсон өөрчлөлтөөр Онцгой байдлын байгууллага нь төрийн цэргийн байгууллага болон зарим үйл ажиллагаа, санхүүгийн холбогдох мэдээлэл нууцын зэрэглэлд хамаарахаар болсон. Шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу нууцын зэрэглэлд хамаарах мэдээллийг ангилан тодорхойлоогүйгээс зарим мэдээллийг шалгах боломжгүй байна.

Онцгой байдлын ерөнхий газар нь шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ нийт 112,002,105.4 мянган төгрөгийн 716 мэдээлэл оруулахаас 29,748,568.4 мянган төгрөгийн 100 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах талаар албан шаардлага, нууцад хамаарахаас бусад шилэн дансны цахим хуудсанд АХГ-2022/164/НА-СТА-ТШЗ

байршуулах мэдээллийг тодорхой болгох, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

Өмнөх оны аудитаар нийт 5 албан шаардлага, 4 зөвлөмж өгснийг үнэлэхэд албан шаардлага 60.0 хувийн, зөвлөмж 75.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	892,639.6	2	365,500.0	2	527,139.6	75.0
Албан шаардлага	5	320,052.2	2	228,052.2	3	92,000.0	60.0
Нийт дүн	9	1,212,691.8	4	15,785.0	5	619,139.6	67.5

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, зөвшөөрөлгүй автомашин бэлтгэсэн албан шаардлага хэрэгжих шатандаа, ОБЕГ-ын аппаратын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх албан шаардлага хэрэгжээгүй;

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор тусгаарлах байруудаар үйлчилж байгаа аж ахуйн нэгжүүдтэй ор хоногийн төлбөрийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, төсвийн урсгал зардлаас зарим зардлыг санхүүжүүлэхийг түр зогсоохтой холбоотой 2 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

Иймд биелээгүй албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Онцгой байдлын ерөнхий газрын авлага, урьдчилж төлсөн зардлын данс, давсан орлого, худалдан авах ажиллагаа болон санхүүгийн зарим мэдээллүүд нууцын зэрэглэлд хамаарч байх тул төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар судалгаа гаргаж, нэгтгэн үр дүнг аудитын тайланд тусгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 244,990.9 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 244,990.9 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 4 зөрчилд зөвлөмж өгөв.

Залруулагдаагүй 7 алдаа, зөрчлийн дүн 244,990.9 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 441,114.5 мянган төгрөгөөс бага тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Албан шаардлага

Аудитаар илэрсэн 244,990.9 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Тайлант онд 244,199.8 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, богино хугацаат зээлийн өглөг 791.1 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн тохируулгын тайлан бүрэн бэлтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5, 54.5.1, 54.5.2, 54.5.3, 54.5.4, 54.5.5, 54.5.6 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 8 "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам"-ын 3а "Төсвийн шууд захирагчийн мөнгөн орлого, зарлагад хийх тохируулгууд" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн санхүүгийн тайланг бүрэн тодруулгатай, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж, төрийн аудитын байгууллагад ирүүлэх талаар албан шаардлага хүргүүлэв.

3. Өмнөх оны аудитаар нийт 5 албан шаардлага, 4 зөвлөмж өгснийг үнэлэхэд албан шаардлага 60.0 хувийн, зөвлөмж 75.0 хувийн хэрэгжилттэй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмыг Монгол Улсын ерөнхий аудитор батална", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл", 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж алдаа зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

АХГ-2022/164/НА-СТА-ТШЗ

1.1. Илрүүлэлт:

Тайлант оны эцэст бичиг хэргийн материалд 20,000.0 мянга, багаж, техник хэрэгсэлд 215,915.0 мянга, бензин шатахуунд 420,000.0 мянган, нийт 655,915.0 мянган төгрөгийг нэр бүхий байгууллагуудад шилжүүлж авлага үүсгэн бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 7 дугаар зүйлийн 7.7 "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ." гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж, авлага, бараа материалын нөөц үүсгэхгүй байх.

2. Үндсэн хөрөнгө, бараа материалын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгө, бараа материалын данстай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Тавилга эд хогшил дансанд 1,159.6 мянган төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий 27 нэр төрлийн тавилга эд хогшлын шинж чанаргүй хөрөнгө, бусад үндсэн хөрөнгийн дансанд нийтийн эзэмшлийн 2 явган хүний зам, байршил тодорхойгүй 1 суварга бүртгэлтэй;
- Санхүүгийн тайлангаарх үндсэн хөрөнгө, бараа материалын дүн хөрөнгийн тооллогын дүнгээс 806,507.1 мянга, тооллогын бүртгэлийн нэгтгэлээс 630,288.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн;
- Санхүүгийн байдлын тайланд бүртгэлтэй 41,112.5 мянган төгрөгийн үнэлгээ бүхий 1 газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа 2017 онд дууссан боловч сунгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 2 "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана.", Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 "Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно.", 35 дугаар зүйлийн 35.1.5 "35.1.5.газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн эзэмшихээр эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах", ОБЕГ-ын даргын 2016 оны А/293 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.4 Үндсэн хөрөнгө гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийг ангиллын дагуу үнэн зөв бүртгэх, хөрөнгийн тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгах, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

АХГ-2022/164/НА-СТА-ТШЗ

Зардлын данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд автомашин бүртгэлгүй ба Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын шатахууны зардлыг ОБЕГ-ын аппаратын төсөвт төлөвлөж, зарцуулсан;
- Багаж, техник, хэрэгслээс 318,284.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бэлтгэсэн;
- Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, бараа үйлчилгээний бусад зардлаас эдийн засгийн ангилал зөрчиж, бусад зардалд гүйлгэн зарцуулсан. Анхан шатны баримт бүрдэл, цахим төлбөрийн баримт хангалтгүй.
- Улсын онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагааны төсвийг батлаагүйгээр 315,733.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.6.7-д "төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Эдийн засгийн ангилал батлах тухай", "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шатахууны зардлыг тухайн харьяа байгууллагын төсөвт төлөвлөж, зарцуулах, батлагдсан төсвийг ангиллын дагуу бүртгэх, зарцуулах, тайлагнах, анхан шатны баримт, цахим төлбөрийн баримтын бүрдлийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

4. Авто тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй улсын дугаар бүхий Hyundai Sonata маркийн суудлын автомашин нь ОБЕГ-ын харьяа Ар талын 115 дугаар ангид бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэж заасантай нийцэхгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд бүртгэлтэй автомашины тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хийлгэж, автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Албан шаардлага, зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс:									
							Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал																
1	Онцгой байдлын ерөнхий газар	АХГ-2022/164/НА-СТА-ТШЗ	Тайлант онд 244,199.8 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, богино хугацаат зээлийн өглөг 791.1 мянган төгрөгөөр зөрүүтэй.	Авлага, өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулах.	1	244,990.9						1	244,990.9			
2	Онцгой байдлын ерөнхий газар	АХГ-2022/164/НА-СТА-ТШЗ	Тайлант оны эцэст бичиг хэргийн материалд 20,000.0 мянга, багаж, техник хэрэгсэлд 215,915.0 мянга, бензин шатахуунд 420,000.0 мянга, нийт 655,915.0 мянган төгрөгийг харилцагчид шилжүүлж авлага үүсгэн бүртгэсэн.	Төсвийг зохистой удирдаж, авлага, бараа материалын нөөц үүсгэхгүй байх.	1	0.0									1	
3	Онцгой байдлын ерөнхий газар	АХГ-2022/164/НА-СТА-ТШЗ	Тавилга эд хогшил дансанд 1,159.6 мянган төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий 27 нэр төрлийн тавилга эд хогшлын шинж чанаргүй хөрөнгө, бусад үндсэн хөрөнгийн дансанд нийтийн эзэмшлийн 2 явган хүний зам, байршил тодорхойгүй 1 суварга бүртгэлтэй; Санхүүгийн тайлангаарх үндсэн хөрөнгө, бараа материалын дүн тооллогын дүнгээс 806,507.1 мянга, тооллогын бүртгэлийн нэгтгэлээс 630,288.7 мянган төгрөгөөр	Үндсэн хөрөнгийг ангиллын дагуу үнэн зөв бүртгэх, хөрөнгийн тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгах, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах.	1	0.0									1	

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

			зөрүүтэй илэрхийлэгдсэн; Санхүүгийн байдлын тайланд бүртгэлтэй 41,112.5 мянган төгрөгийн үнэлгээ бүхий 1 газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа 2017 онд дууссан боловч сунгуулаагүй.													
4	Онцгой байдлын ерөнхий газар	АХГ- 2022/164/ НА-СТА- ТШЗ	ТТЗ-ийн харьяа байгууллагуудын шатахууны зардлыг ОБЕГ-ын аппаратын төсөвт төлөвлөж, зарцуулсан; Багаж, техник, хэрэгслээс 318,284.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бэлтгэсэн; Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, бараа үйлчилгээний бусад зардлаас эдийн засгийн ангилал зөрчиж, бусад зардалд гүйлгэн зарцуулсан. Анхан баримт бүрдэл, цахим төлбөрийн баримт хангалтгүй. УОК-ын шуурхай штабын үйл ажиллагааны төсвийг батлаагүйгээр зардал гаргасан.	Шатахууны зардлыг тухайн харьяа байгууллагын төсөвт төлөвлөж, зарцуулах, батлагдсан төсвийг ангиллын дагуу бүртгэх, зарцуулах, тайлагнах, анхан шатны баримт, цахим төлбөрийн баримтын бүрдлийг хангаж ажиллах.	1	0.0									1	
5	Онцгой байдлын ерөнхий газар	АХГ- 2022/164/ НА-СТА- ТШЗ	Тус байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй улсын дугаар бүхий Hyundai Sonata маркийн суудлын автомашин нь ОБЕГ-ын харьяа Ар талын 115 дугаар ангид бүртгэлтэй.	Автомашин тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хийлгэж, автомашин тээврийн хэрэгслийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах.	1	0.0									1	
6	Онцгой байдлын	АХГ- 2022/164/	Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн	Жилийн эцсийн санхүүгийн тайланг	1	0.0					1	0.0				

Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	ерөнхий газар	НА-СТА-ТШЗ	тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн тохируулгын тайлан бүрэн бэлтгээгүй.	бүрэн тодруулгатай, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэх.												
7	Онцгой байдлын ерөнхий газар	АХГ-2022/164/НА-СТА-ТШЗ	Өмнөх оны аудитаар нийт 5 албан шаардлага, 4 зөвлөмж өгснийг үнэлэхэд албан шаардлагын хэрэгжилт 60.0 хувь, зөвлөмж 75.0 хувийн хэрэгжилттэй.	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх.	1	0.0					1	0.0				
Дүн					7	244,990.9	0	0.0	0	0.0	3	244,990.9	0	0.0	4	0.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	Онцгой байдлын ерөнхий газар	АХГ-2022/164/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу нууцын зэрэглэлд хамаарах мэдээллийг ангилан тодорхойлоогүйгээс зарим мэдээллийг шалгах боломжгүй. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 24,486,762.7 мянган төгрөгийн 57, зарлагын 3,133,425.5 мянган төгрөгийн 42 ажил гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн.	Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах, нууцад хамаарахаас бусад шилэн дансанд байршуулах мэдээллийг тодорхой болгох.	1	3,133,425.5					1	3,133,425.5				
Дүн					1	3,133,425.5	0	0.0	0	0.0	1	3,133,425.5	0	0.0	0	0.0
Нийт дүн					8	3,378,416.4	0	0.0	0	0.0	4	3,378,416.4	0	0.0	4	0.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 174/АО/50058

Улаанбаатар хот

АХГ - 2022/164/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланг батлагдсан загварын дагуу бэлтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5, 54.5.1, 54.5.2, 54.5.3, 54.5.4, 54.5.5, 54.5.6 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 8 "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам"-ын 3а "Төсвийн шууд захирагчийн мөнгөн орлого, зарлагад хийх тохируулгууд" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Жилийн эцсийн санхүүгийн тайланг бүрэн тодруулгатай, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж, төрийн аудитын байгууллагад ирүүлж байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын Ар тал, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа Я.Гантөмөр, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч М.Хаш-Эрдэнэ, ахлах нягтлан бодогч Ц.Бямбацогт нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ц.ЭНХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherag\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-185.Docx

0010800602



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 231/А0150058
АХГ-2022/164/НА-СТХ-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар нийт 5 албан шаардлага, 4 зөвлөмж өгснийг үнэлэхэд албан шаардлага 60 хувийн, зөвлөмж 75.0 хувийн хэрэгжилттэй байна. Үүнд:

- Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор тусгаарлах байруудаар үйлчилж байгаа аж ахуйн нэгжүүдтэй ор хоногийн төлбөрийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, төсвийн урсгал зардлаас зарим зардлыг санхүүжүүлэхийг түр зогсоохтой холбоотой 2 зөвлөмж хэрэгжих шатандаа;
- Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, зөвшөөрөлгүй автомашин бэлтгэсэн 2 албан шаардлага хэрэгжих шатандаа, Онцгой байдлын ерөнхий газрын аппаратын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх 1 албан шаардлага хэрэгжээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмыг Монгол Улсын ерөнхий аудитор батална", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл", 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж алдаа зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;


2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын Ар тал санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа Я.Гантөмөр, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч М.Хаш-Эрдэнэ, ахлах нягтлан бодогч Ц.Бямбацогт нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Ц.ЭНХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 233/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/164/НА-СТА-ТМС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 244,199,788.64 төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, богино хугацаат зээлийн өглөг 791,074.93 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын Ар тал, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа Я.Гантөмөр, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч М.Хаш-Эрдэнэ, ахлах нягтлан бодогч Ц.Бямбацогт нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ц.ЭНХЖАРГАЛ

00108C0778

[illegible]

[illegible]